

ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд тавигдах шаардлага, зээлдүүлж болох үнэт цаасны төрөл, гэрээний нөхцөл, барьцаа хөрөнгийн удирдлага, оролцогч талуудын эрх, үүрэг, мэдээллийн тайлагналтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэ журмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад хамаарахгүй хязгаарлагдмал хариуцлагатай компани, хаалттай хувьцаат компанийн үнэт цаас, зохицуулалттай зах зээлд арилжаалахыг зөвшөөрөөгүй бусад төрлийн үнэт цаасыг зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахгүй.

ХОЁР. ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

- 2.1. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээтэй холбоотой хэлцлийг зохион байгуулах, барьцаа хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, өдөр тутмын үнэлгээ болон эрсдэлийн менежмент хийх, гэрээ болон холбогдох баримт бичгийг баталгаажуулж хадгалах, мэдээлэл тайлагнах зэрэг үйл ажиллагааг дараах этгээд хэрэгжүүлнэ:
 - 2.1.1. Үнэт цаасны номиналь дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл авсан Үнэт цаасны компани (цаашид “ҮЦК” гэх);
 - 2.1.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага (цаашид “ҮЦТХТ” гэх).
- 2.2. ҮЦТХТ, ҮЦК нь энэ журмын 3.1-д заасан гэрээг байгуулахаас өмнө зээлдэгчийг таньж мэдэх, түүний санхүүгийн чадамж, барьцаа хөрөнгө, хөрөнгө оруулалтын туршлагыг хянасны үндсэн дээр үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээг үзүүлнэ.
- 2.3. ҮЦК нь үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэхдээ өмчлөх эрх нь өөрийн нэр дээр бүртгэлтэй үнэт цаасыг зээлдүүлнэ.
- 2.4. ҮЦК өөрийн харилцагчаас зээлдэж авсан үнэт цаасыг бусад харилцагчид зээлдүүлэх үнэт цаасны сагсыг бүрдүүлэх зорилгоор үнэт цаас зээлдэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлж болно.
- 2.5. ҮЦК энэ журмын 2.4-т заасны дагуу харилцагчаас зээлдэж авсан үнэт цаасыг зээлдүүлэх тохиолдолд тухайн харилцагчийн зөвшөөрлийг тухай бүр урьдчилан авч, энэ журмын 3.1-д заасан гэрээг байгуулна.
- 2.6. ҮЦК нь үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-д заасан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгал, дилерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд болон мэргэжлийн хөрөнгө оруулагчийн дараах шаардлагыг хангасан иргэнд үзүүлнэ:
 - 2.6.1. тухайн иргэний сүүлийн нэг жилийн сарын дундаж орлого нь 10 сая төгрөгтэй тэнцүү болон түүнээс дээш хэмжээтэй, эсхүл 500 сая төгрөгөөс дээш хэмжээний цэвэр хөрөнгө /харилцах, хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгө, үнэт цаасны нийлбэр дүнгээс өр төлбөрийг хасах/-тэй байх;

- 2.6.2. сүүлийн 1 жилийн турш дотоодын болон гадаадын зах зээл дээр үнэт цаасны арилжаанд оролцсон туршлагатай байх.
- 2.7. ҮЦК нь кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ үзүүлсэнтэй холбогдуулан харилцагчийн өмчлөх эрхийн тухайлсан бүртгэлийг хөтлүүлнэ.
- 2.8. ҮЦТХТ нь үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-д заасан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгал, дилерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд үзүүлнэ.
- 2.9. Зээлдүүлэгч нь нээлттэй арилжаалагддаг Засгийн газар, аймаг, нийслэлийн үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагын бонд, компанийн бонд, хувьцаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хамтын хаалттай сангийн нэгж эрх, үнэт цаасны зах зээлд арилжаалахаар гаргасан хадгаламжийн сертификатыг зээлдүүлнэ.
- 2.10. Зээлдэгч нь нээлттэй арилжаалагддаг хувьцааг зээлдэж авсны дараагаар тухайн компанийн эзэмших нийт хувьцааны хэмжээ нь компанийн хувьцааны хяналтын багцаас ихгүй байна.
- 2.11. ҮЦТХТ, ҮЦК нь зээлдүүлэх боломжтой үнэт цаасны талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ.
- 2.12. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбогдсон нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг тогтоож, Хороогоор батламжлуулна.

ГУРАВ. ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

- 3.1. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд оролцож буй зээлдүүлэгч болон зээлдэгч талууд “Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх гэрээ” (цаашид “гэрээ” гэх)-г Олон улсын үнэт цаас зээлдүүлэх холбоо (ISLA)-ны зарчмуудад тулгуурлан харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулах бөгөөд уг гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:
- 3.1.1. талуудын хууль ёсны нэр, хаяг, иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар болон бусад шаардлагатай мэдээлэл;
 - 3.1.2. зээлдүүлэх үнэт цаасны төрөл, тоо хэмжээ, төрөл тус бүрийн болон нийт үнийн дүн;
 - 3.1.3. зээлийн хугацаа;
 - 3.1.4. барьцаа хөрөнгийн болон барьцаа хөрөнгө үнэт цаас байх тохиолдолд хорогдуулалтын хувь;
 - 3.1.5. үйлчилгээний шимтгэлийн хувь хэмжээ, төлөх давтамж, тооцож эхлэх хугацаа;
 - 3.1.6. барьцаанд тавьсан мөнгөн хөрөнгийг хадгаламжид байршуулах тохиолдолд хүү тооцож эхлэх болон дуусах өдөр;
 - 3.1.7. талуудын эрх, үүрэг, хариуцлага;
 - 3.1.8. бусад.
- 3.2. Гэрээнд дараах анхааруулгыг тодоор бичсэн байна:
- “Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээний хүрээнд зээлдэгч тал гэрээнд заасан хугацаанд зээлдүүлсэн үнэт цаасыг буцаан нийлүүлэх үүргээ биелүүлж чадахгүй болох, улмаар зээлдүүлсэн үнэт цаасаа бүрэн хэмжээгээр буцаан авч чадахгүй болох ЭРСДЭЛТЭЙ үйлдэл гэдгийг онцгойлон анхаарч, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх

үйлчилгээнд оролцохоосоо өмнө холбогдох эрсдэл, нөхцөлийг сайтар судалж, өөрийн санхүүгийн боломжид тулгуурлан зээлдүүлэх шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”

- 3.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд ҮЦК нь гэрээний хуулбарыг ҮЦТХТ, эсхүл кастодианд тухай бүр хүргүүлнэ.
- 3.4. Зээлдүүлэгч үнэт цаасыг зээлдэгчид шилжүүлж, зээлдэгч барьцаа хөрөнгийг барьцаалуулсанаар тухайн гэрээ хүчин төгөлдөр болно.
- 3.5. Зээлдүүлсэн үнэт цаасны хүүгийн орлого, хувьцааны ногдол ашиг, саналын эрх зэрэг өмчлөх эрхтэй холбоотой тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх эрх гэрээний хугацаанд зээлдэгчид шилжинэ.
- 3.6. Талуудын гэрээнд өөрөөр заагаагүй бол зээлдэгч нь зээлдэж авсан үнэт цаастай холбоотой аливаа шимтгэл, хураамж болон бусад холбогдох зардлыг өөрөө хариуцах бөгөөд зээлдүүлэгч нь барьцаа хөрөнгөтэй холбогдох зардлыг хариуцна.

ДӨРӨВ. БАРЬЦАА ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

- 4.1. Зээлдэгч нь зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханшид суурилан үнэт цаасыг эргэн төлөх баталгаа болгон барьцаа хөрөнгийг байршуулах бөгөөд барьцаа хөрөнгө нь бэлэн мөнгө, нээлттэй арилжаалагддаг Засгийн газар, аймаг, нийслэлийн үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан бонд, компанийн бонд, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын I ангилалд бүртгэлтэй компанийн хувьцаа, үнэт цаасны зах зээлд арилжаалахаар гаргасан хадгаламжийн сертификат болон аккредитиваас бүрдэнэ.
- 4.2. Энэ журмын 4.1-т заасан барьцаа нь мөнгөн хөрөнгө, эсхүл аккредитив байх тохиолдолд зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханшаас багагүй, эсхүл үнэт цаас хэлбэртэй байх тохиолдолд зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханшаас дээш дүнтэй байх бөгөөд энэ тохиолдолд хорогдуулалтын хувь хэмжээг гэрээнд тусгана.
- 4.3. Зээлдэгч болон зээлдүүлэгч хоорондоо тохиролцсон бол зээлдэгч нь зээлээр авсан үнэт цаасаа буцаан олгох хүртэл зээлдүүлэгч нь барьцаанд байгаа бэлэн мөнгийг арилжааны банкны тусгайлан нээсэн харилцах, эсхүл мөнгөн хадгаламжид тусад нь хадгалуулах бөгөөд мөнгөн хадгаламжид хадгалуулах тохиолдолд хадгаламжийн хүүгийн орлогын хэмжээ, төлбөрийн нөхцөлийг талууд тохиролцсоны үндсэн дээр гэрээнд тодорхой заана.
- 4.4. Барьцаа хөрөнгө үнэт цаас хэлбэртэй байх тохиолдолд тухайн барьцаа хөрөнгийг тусгаарлах үйл ажиллагааг ҮЦТХТ, эсхүл кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд гүйцэтгэнэ.
- 4.5. ҮЦТХТ нь энэ журмын 4.4-т заасан барьцаа хөрөнгийг тусгаарлахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг тогтоож, Хороогоор батламжлуулна.
- 4.6. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь энэ журмын 4.4-т заасан барьцаа хөрөнгийг тусгаарлахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг боловсруулж, Хорооны саналыг авч тусгасны үндсэн дээр үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.
- 4.7. ҮЦТХТ, ҮЦК нь зээлдүүлсэн үнэт цаасны зах зээлийн ханшид үндэслэн барьцаа хөрөнгийн үнэлгээг өдөр тутам тооцоолох бөгөөд барьцаа хөрөнгийн үнэлгээ багассан тохиолдолд нэмэлт барьцаа байршуулахыг зээлдэгчээс шаардана.

ТАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Зээлдүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй байна:

- 5.1.1. талууд гэрээгээр тохиролцсон бол зээлдүүлсэн үнэт цаастай холбоотой ногдол ашиг, хүүгийн орлого зэрэг тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх;

- 5.1.2. барьцаа хөрөнгийн үнэлгээ анх байршуулсан дүнгээс бага болсон тохиолдолд зээлдэгчээс нэмэлт барьцаа байршуулахыг шаардах;
- 5.1.3. зээлдэгч төлбөрийн чадваргүй, эсхүл гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд барьцаа хөрөнгийг захиран зарцуулж, зээлдүүлсэн үнэт цаасыг дахин худалдан авахад ашиглах.

5.2.Зээлдэгч нь дараах эрх, үүрэгтэй байна:

- 5.2.1. гэрээнд заасан нөхцөлийн дагуу зээлдэж авсан үнэт цаасыг тодорхой хугацаанд ашиглах, зээлдүүлэгчид буцаан олгох;
- 5.2.2. зээлж авсан үнэт цаасыг эргэн төлөх баталгаа болгон зээлдүүлэгчийн шаардсан барьцаа хөрөнгийг гэрээнд заасны дагуу байршуулах;
- 5.2.3. шаардлагатай барьцаа хөрөнгийн хэмжээ анх байршуулсан барьцаа хөрөнгийн хэмжээнээс буурсан тохиолдолд нэмэлт барьцаа хөрөнгө байршуулах;
- 5.2.4. зээлж авсан үнэт цаастай холбоотой ногдол ашиг, хүүгийн орлого, саналын эрх зэрэг тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх;
- 5.2.5. барьцаанд тавьсан үнэт цаасны хүү, ногдол ашгийн орлого болон саналын эрх зэрэг үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх;
- 5.2.6. гэрээгээр тохиролцсон мэдээллийг зээлдүүлэгчид гаргаж өгөх;
- 5.2.7. гэрээ дуусгавар болох, эсхүл аль нэг талын санаачилгаар цуцлах үед зээлж авсан үнэт цаасыг зээлдүүлэгчид буцаан шилжүүлэх;
- 5.2.8. барьцаанд тавьсан үнэт цаасыг давхар барьцаалахгүй;
- 5.2.9. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбогдон үүсэж болзошгүй эрсдэлийн тухай мэдээлэлтэй урьдчилан танилцсан байх.

5.3.ҮЦТХТ, ҮЦК нь дараах эрх, үүрэгтэй байна:

- 5.3.1. үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэх тухай нарийвчилсан журамтай байх;
- 5.3.2. үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай шуурхай, тасралтгүй, үйл ажиллагааны онцлогт тохирсон программ хангамжтай байх;
- 5.3.3. зээлийн эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор шаардлагатай барьцаа хөрөнгийн хэмжээг өдөр бүр тооцоолох;
- 5.3.4. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой гэрээ, заавар, баримт бичиг болон холбогдох бусад бүртгэлийг цахим болон цаасан хэлбэрээр хадгалах.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

6.1.ҮЦТХТ, ҮЦК нь үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээтэй холбоотой мэдээллийг тус Хороонд дараах хугацаанд цахимаар хүргүүлнэ:

- 6.1.1. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой оролцогч талууд хооронд байгуулсан гэрээ, гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг дараа сарын 10-ны өдрийн дотор;
- 6.1.2. энэ журмын хавсралтаар баталсан үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээний хүрээнд хийгдсэн хэлцлийн сар бүрийн мэдээллийг дараа сарын 05-ны өдрийн дотор;
- 6.1.3. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой үйлчилгээний шимтгэлийн хувь, түүнд өөрчлөлт орсон бол шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор;

- 6.1.4. зээлдэгч гэрээний үүргээ биелүүлээгүй, үнэт цаасаа буцаан өгөх чадваргүй болсон тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр;
- 6.1.5. үнэт цаас зээлдүүлэх гэрээтэй холбоотой маргаан шүүх, хяналтын байгууллагад шилжсэн тохиолдолд тухай бүр.

~oOo~

